55

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 07 өдөр Дугаар 18 Улаанбаатар хот

Хууль, шийдвэрийн хэрэгжилтийг хангах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлийн XYII.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа агентлаг, байгууллагын дарга, захирал, албан тушаалтанд үүрэг болгосугай:

1.1. Захиргааны ерөнхий хуулийг байгууллага, нэгжийн хэмжээнд танилцуулан сурталчлах сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах;

1.2. Захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаанд Захиргааны ерөнхий хуульд заасан дараах шаардлагыг онцгойлон анхаарч хэрэгжүүлэх;

1.2.а/ иргэн, хуулийн этгээдээс эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар гаргасан өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэж байх;

1.2.б/ захиргааны шийдвэр гаргах, салбарын бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхийн өмнө Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд мэдэгдэж, тэдгээрийг сонсох ажиллагааг зохион байгуулж ажиллах;

1.2.в/ захиргааны шийдвэрийн хувийн хэрэг, хяналтын дагалдах хуудсыг бичмэл хэлбэрээр гаргах захиргааны шийдвэр бүрт хөтөлж, дагалдах хуудасны тэмдэглэл хөтлөлтийн бүрдлийг хангуулж хэвшүүлэх;

1.2.г/ захиргааны актыг хаяглагдсан болон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасан журмын дагуу мэдэгдэж, баримтжуулж байх;

1.2.д/ захиргааны хэм хэмжээний актын төслийг бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийж, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байршуулж иргэд, байгууллагын саналыг авч ажиллах;

1.2.е/ захиргааны хэм хэмжээний актаар хуулиар хориглоогүй, тогтоогоогүй асуудлаар хориглосон зохицуулалт, нэмэлт шаардлага, бичиг баримт, төлбөр хураамж тогтоохгүй байх;

1.2.ё/ нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх захиргааны хэм хэмжээний актын төсөл бүрт эрх ашиг сонирхол нь зөрчигдөх этгээдийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж байх;

1.2.ж/ захиргааны хэм хэмжээний актыг баталснаас хойш ажлын 5 хоногт багтаан Захиргааны ерөнхий хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт заасан баримт бичгийн бүрдлийг ханган Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх;

1.2.з/ яам, байгууллага бүрт салбарын захиргааны хэм хэмжээний актын цахим санг бүрдүүлж, хариуцсан ажилтныг томилон ажиллуулах;

1.2.и/ Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг албан үүргийн хүрээнд хэрхэн ханган ажиллаж байгаа үзүүлэлтийг ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусган, ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулах, ажлын үр дүнг үнэлж дүгнэхэд тооцож ажиллах;

1.2.й/ Захиргааны ерөнхий хууль зөрчигдсөн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй тохиолдолд буруутай албан тушаалтанд зохих хариуцлагыг тооцож ажиллах.

2. Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хариуцсан газар, хэлтсийнхээ чиг үүрэгт хамаарах өмнө батлагдсан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээний актад тавих шаардлагад нийцүүлэн өөрчлөх, хүчингүй болгох саналыг хавсралт хүснэгтийн дагуу гаргаж, Хуулийн хэлтсээр хянуулан холбогдох баримт бичгийн хамтаар 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн яамны газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлийн XYII.2 дахь заалтаар өгсөн үүрэг даалгаврын хүрээнд энэ тушаалын 2 дахь заалтад заасан ажлыг хариуцсан агентлаг, байгууллагадаа зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа агентлаг, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг, байгууллагад хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /Ж.Гантөмөр/-т, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т тус тус даалгасугай.

САЙД Д.ГАНБАТ

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн даргын ... оны ... дугаар тушаал

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 09 дүгээр сарын
07 –ний өдрийн 18 дугаар тушаалын хавсралт

УХА0382
5919487
1116126781

Зам, тээврийн салбарын хэмжээнд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр нь Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээний актад тавих шаардлагад нийцсэн байдлын судалгаа

№	Тушаалын нэр, огноо, утга	Захиргааны хэм хэмжээний актыг батлах эрх олгосон хуулийн заалт	Улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэх, бүртгэлийн дугаар	Захиргааны ерөнхий хуулийн шаардлага /+, - тэмдэглэгээгээр тэмдэглэнэ/										Хэрхэн шийдвэрлэх санал /өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, шинэчлэх/
				Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд нийцсэн байх;	тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх	тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заасан байх	шийдвэрийн заалт хоорондоо болон эрх бүхий бусад этгээдийн гаргасан шийдвэрийн заалттай зөрчилдөхгүй байх	Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэсэн байх	хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоосон эсэх	тухайн шийдвэрээр урьд нь гарсан шийдвэрийг хүчингүй болсонд тооцож байгаа, эсхүл түүнд өөрчлөлт оруулж байгаа бол энэ тухай заалтыг тусгасан байх	бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх	баталсан байгууллага, албан тушаалтны болон захиргааны хэм хэмжээний актын нэр, он, сар, өдөр, дугаарыг тодорхой заасан байх	хуульд заасан бусад шаардлага /салбарын болон бусад хуулиар/	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1														
2														
3														
4														
5														

Тайлбар:

* Газар, хэлтсүүд нь хариуцсан чиг үүрэгтээ хамаарах Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2016.07.01-нээс өмнө баталсан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг судалгаанд нэг бүрчлэн, бүрэн хамруулах бөгөөд судалгааг гаргахад Хуулийн хэлтсийн тухайн салбар хариуцсан албан хаагчаас удирдамж зөвлөгөө авч болно.

** Газар, хэлтсүүд нь чиг үүрэгтээ хамаарах өмнө батлагдсан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээний актад тавих шаардлагад нийцүүлэн өөрчлөх, хүчингүй болгох саналтай бол өөрчлөлт оруулах, шинэчлэх, хүчингүй болгох тухай тушаалын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг хангуулан хамтад нь боловсруулж ирүүлнэ.

*** Судалгааг хариуцан гаргасан албан хаагчид нь газар, хэлтсийн болон Хуулийн хэлтсийн тухайн салбар хариуцсан албан хаагчаар хянуулан 2016.09.15-ны өдрийн дотор ТЗУГ-т ирүүлнэ.